



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.6.15 № 6.1/3891

танай _____-ны № _____-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг
түр түдгэлзүүлэх тухай

Танай яамнаас зарласан "1:50000-ны маштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил"-ын 6 төсөл, "Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" хамтарсан төслийн 4-р үе шатны сэдэвчилсэн судалгааны 1 төслүүдийг тус тус хэрэгжүүлэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн 5 дугаар багцад оролцсон "Монголит" ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргаад байна.

Иймд дээрх хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна. Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2018 оны 06 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр
2. Тендерийн урилга /сонинд зарласан хуулбар/
3. Тендерийн баримт бичиг
4. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл
6. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр
7. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг
8. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээ, холбогдох бусад баримт бичиг
9. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй талаар мэдэгдлийг оролцогч нарт хүргүүлсэн талаар нотлох баримт

Гомдлыг хянах явцад тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, уг хугацааг сунгуулах арга хэмжээ авч ажиллана уу.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА

П.БИЛГҮҮН



САНГИЙН ЯАМНЫ ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА
П.БИЛГҮҮН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018.06.20 № 03/1717
танай 2018.06.15-ны № 6-1/3891-т

**Тендер шалгаруулалтын
баримт бичгийн тухай**

Танай 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн "Гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай" 6-1/3891 тоот албан бичигтэй танилцлаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай" А/02 дугаар тушаалаар Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 онд шинээр хэрэгжүүлэх геологи, хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог байгуулан "1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил"-ын 6 төсөл, "Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" хамтарсан төслийн IV үе шатны сэдэвчилсэн судалгааны 1 төслүүдийг тус тус хэрэгжүүлэх зөвлөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс хураангуй жагсаалтыг үүсгэн, хураангуй жагсаалтад нэр нь орсон зөвлөхүүдэд 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр саналын урилга болон Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг хүргүүлж 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр тендерийг нээсэн.

Зөвлөхүүдийн саналыг хянан үзэж, техникийн саналыг үнэлэн, техникийн саналд авбал зохих доод буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдэд санхүүгийн саналыг нээх хугацааг мэдэгдэж, 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 14.00 цагт санхүүгийн саналыг нээх гэж байна.

Тендерийн үнэлгээний явцад тендерт оролцогчдоос тендер шалгаруулалттай холбогдуулан захиалагчид гомдол гараагүй бөгөөд үнэлгээний хорооноос зөвлөхийн тендерийн үнэлгээний үе шатын дагуу үнэлгээг хийж байна.

Иймд тухайн тендерийн үнэлгээ дуусаагүй, захиалагчийн гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гараагүй байгаа тул танай "Гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай" албан тоотоор шаардсан баримт бичгийн бүрдэл одоогоор хангагдаагүй байгааг албан ёсоор мэдэгдэж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА П.НАНДИНЖАРГАЛ



08 1873



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.6.25. № 6-1/4092
Танай _____-ны № _____

УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Тендер шалгаруулалтын тухай

Танай яамнаас зарласан "1:50000-ны маштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил"-ын 6 төсөл, "Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" хамтарсан төслийн 4-р үе шатны сэдэвчилсэн судалгааны 1 төслүүдийг тус тус хэрэгжүүлэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн 5 дугаар багцад оролцсон "Монголит" ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргасны дагуу тус яамнаас гүйцэтгэгч сонгох ажиллагааг түдгэлзүүлж, гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт, материалуудыг ирүүлэхийг хүссэн тухай 6-1/3891 тоот албан бичгийг танайд хүргүүлсэн байна.


Гэтэл баримт бичгийн бүрдэл хангагдаагүй тул баримт, материалыг ирүүлэх боломжгүй тухай 03/1717 тоот албан бичиг тус яаманд ирээд байна.

Захиалагч буюу танай байгууллага тендерт оролцогч "Монголит" ХХК-д 03/1615 тоот албан бичгээр захиалагчийн шийдвэрийг хүргүүлсэн байх тендерт оролцогч нь уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу тус яаманд гомдол гаргах эрхтэй бөгөөд тус яам хуулийн 55.2-т заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Иймд тухайн гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт, материалыг тус яаманд яаралтай ирүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана уу.

Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх болгохыг үүгээр анхааруулж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.НАРАНЦОГТ



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.НАРАНЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018.07.03 № 03/1835
танай 2018.06.25-ны № 6-1/4092 -т

Тендерийн материал хүргүүлж,
хүчинтэй хугацааг сунгуулах тухай

Танай 2016 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Тендер шалгаруулалтын тухай" 6-1/4092 тоот албан бичигтэй танилцлаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2018 оны 04 сарын 19-ний өдөр зарласан "1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил"-ын 6 төсөл, "Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" хамтарсан төслийн IV үе шатны сэдэвчилсэн судалгааны 1 төслүүдийг тус тус хэрэгжүүлэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн Багц-5-д "Монголит" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд Тендерийн баримт бичиг/ТББ/-ийн 5.2-т заасан ерөнхий шаардлагыг хангаагүй, ТӨЗ.4.5.8-ын 10 дугаарт заасан тооцоо нийлсэн актыг ирүүлээгүй, Захиалагчийн баталсан геологийн даалгаварт тусгагдсан талбайн геофизикийн ажлыг техникийн саналд тусгаагүй байсан ба тендерийн бүрдлийг хангаагүй тул тендерээс татгалзсан болно.

"Монголит" ХХК-ийн гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт, материалыг хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

1. Үнэлгээний хороог байгуулсан шийдвэр ба гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар;
2. Тендерийн анхны урилга/сонинд зарласан хуулбар/, зөвлөх үйлчилгээний 2 дах зарлал ба саналын урилгын хуулбар;
3. Тендерийн баримт бичиг/pdf файлаар/;
4. Тендерийн Багц-5-д ирүүлсэн 4 оролцогчийн тендер/pdf файлаар/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл, шийдвэр;
6. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр, гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй талаар мэдэгдлийг оролцогч нарт хүргүүлсэн талаар нотлох баримт;

Сангийн яаманд гомдлыг хянах явцад, 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдөр тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу уг тендерийн 5 дугаар багцын хувьд тендерийн хүчинтэй байх хугацааг 30 хоноогоор сунгах зөвшөөрлийг олгож манай ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

08 1971



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>


2018. 7. 6. № 6.1/3500
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын тухай

Танай яамнаас зарласан “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил”-ын 6 төсөл, “Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” хамтарсан төслийн 4 дүгээр үе шатны сэдэвчилсэн судалгааны 1 төслүүдийг тус тус хэрэгжүүлэх зөвлөхийг сонгон шалгаруулах” тендерт оролцсон “Монголит” ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гарган тус яамнаас тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн бөгөөд тус компани нь гаргасан гомдлоо эргүүлэн татсан тул тендер шалгаруулалтыг цааш үргэлжлүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулах хүсэлтэй байгаа тухай танай 03/1835 тоот албан бичигтэй танилцаж хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу нэг удаа 30 хоногоор сунгаж байна. Тус хугацаа нь тендерийн хүчинтэй хугацаа дууссан өдрөөс эхлэн тоологдох болохыг анхаарна уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

0 6442